


Мөнгөний тойм

2012 оны 3 дугаар сар

Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс¹ 2012 оны 3 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 2.2 хувь, оны эхнээс 7.6 хувь, өмнөх оны мөн үеэс 15.3 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сарынхаас 2.5 хувь, оны эхнээс 8.2 хувь, өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар тус тус өслөө. Суурь инфляци² сарын 0.2 хувь, оны эхнээс 2.6 хувь, жилийн 11.3 хувь байв.




Улаанбаатар хотын сарын инфляцид хүнсний барааны үнийн өсөлт нөлөөлсөн бөгөөд хонины махны үнэ 19.0 хувь, үхрийн махных 10.8 хувиар тус тус өссөн нь сарын инфляцийн 91.6 хувийг бүрдүүлж байна.

Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлтийг бүлгээр нь авч үзвэл хүнсний барааны үнэ 28.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 19.8 хувь,

тээврийн бүлгийнх 18.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 12.6 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр өсөлттэй бүлгүүд байлаа.


2011 оны турш Улаанбаатар хотын жилийн инфляцид хүнснээс бусад бараа,

бүтээгдэхүүний үнийн өсөлт илүү нөлөөлж байсан бол тайлант сард хүнсний барааны үнийн өсөлтийн нөлөө огцом өсчээ.



Мөнгөний нийлүүлэлт

Мөнгөний нийлүүлэлт³ өмнөх сараас 2.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 23.2 хувиар өсч 6104.8 тэрбум төгрөгт хүрэв. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2011 оны 7 дугаар сараас хойш буурсаар байгаа бөгөөд жилийн өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 43.4 нэгж хувиар саарсан байна.



Тайлант сард валютын хадгаламжийн жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 22.2 нэгж хувь, төгрөгийн харилцахынх

¹ Үндэсний Статистикийн Хорооны мэдээ.

² Мах, сүү, хүнсний ногоог хэрэглээний сагснаас хасч тооцов.


³ M2-мөнгөний нийлүүлэлт нь Баргаг мөнгө, M1 мөнгөний нийлбэр.

19.1 нэгж хувь, банкнаас гадуурх мөнгөнийх 20.4 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 2.1 нэгж хувиар тус тус буурч, харин валютын харилцахынх 26.9 нэгж хувиар өсчээ.

2012 оны 3 дугаар сарын мөнгөний үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг үлдэгдлээр нь авч үзвэл валютын харилцах, хадгаламжаас бусад үзүүлэлтүүд харьцангуй өөрчлөлт багатай байсан бөгөөд валютын хадгаламж өмнөх сараас 234.0 тэрбум төгрөгөөр буурч, харин валютын харилцах 128.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.



M2 мөнгөний жилийн өсөлтийн 55.8 хувийг төгрөгийн хадгаламж, 21.3 хувийг төгрөгийн харилцах, 19.9 хувийг гадаад валютын харилцах, 5.3 хувийг банкнаас гадуурх мөнгө, -2.4 хувийг гадаад валютын хадгаламж тус тус бүрдүүлжээ.



Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сарынхаас 6.2 хувь буюу 248.9 тэрбум төгрөгөөр буурч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 19.6 хувь буюу 614.7 тэрбум төгрөгөөр өсч 3746.3 тэрбум төгрөгт хүрэв.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сарынхаас 0.2 хувь буюу 0.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 6.8 хувь буюу 18.4 тэрбум төгрөгөөр буурч 251.5 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сарынхаас 0.5 хувь буюу 14.2 тэрбум төгрөгөөр буурч, харин өнгөрсөн оны мөн үеэс 31.9 хувь буюу 660.4 тэрбум төгрөгөөр өсч 2729.2 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сарынхаас 23.4 хувь буюу 234.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 3.4 хувь буюу 27.3 тэрбум төгрөгөөр буурч 765.6 тэрбум төгрөг болжээ.


Нийт хадгаламжийн 79.6 хувь нь төгрөгийн, 20.4 хувь нь валютын хадгаламж байсан бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт хадгаламжинд эзлэх хувь өмнөх сарынхаас 4.6 нэгж хувиар нэмэгдсэн байна.



Гадаад, дотоод цэвэр актив

Гадаад цэвэр актив өмнөх сарынхаас 17.5 хувь, өмнөх оны мөн үеэс 27.9 хувиар өсч

3349.5 тэрбум төгрөг, дотоод цэвэр актив өмнөх сарынхаас 18.7 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар өсч 2755.3 тэрбум төгрөг болов.



Гадаад цэвэр активын дийлэнх хувийг эзэлдэг гадаад валютын цэвэр албан нөөц 2012 оны 3 дугаар сард өмнөх сараас 18.7 хувь буюу 415.7 сая ам.доллар, өмнөх оны мөн үеэс 22.9 хувь буюу 491.4 сая ам.доллараар нэмэгдэж 2633.3 сая ам.доллар болов.

Тайлант сард гадаад цэвэр актив болон гадаад валютын цэвэр албан нөөц ийнхүү их хэмжээгээр өссөн нь Хөгжлийн банк олон улсын зах зээлд бонд гаргасантай холбоотой.



Нийт мөнгөний 54.9 хувь нь гадаад цэвэр активт, 45.1 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна.

Нөөц мөнгө

Нөөц мөнгө өмнөх сарынхаас 19.6 хувь, өмнөх оны мөн үеэс 78.0 хувиар өсч 1814.6 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард Төв банкинд дахь харилцах, хадгаламж 38.3 хувь буюу 323.3 тэрбум төгрөгөөр өсч, харин банкнаас гадуурх мөнгө 2.3 хувь буюу 10.3 тэрбум төгрөг, банкуудын касс 7.0 хувь буюу 15.0 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ.



Банкуудын Төв банкинд дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 16.3 нэгж хувиар нэмэгдэж 64.4 хувь болсон бол банкуудын кассын эзлэх хувь 3.1 нэгж хувиар буурч 10.9 хувь, банкнаас гадуурх мөнгөнийх 13.3 нэгж хувиар буурч 24.7 хувь болсон байна.

Зээл

Хадгаламжийн байгууллагуудаас⁴ олгосон зээл өмнөх сарынхаас 1.3 хувь буюу 75.3 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 55.0 хувь буюу 2050.7 тэрбум төгрөгөөр өсч 5781.5 тэрбум төгрөгт хүрчээ. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон нийт зээл өмнөх

⁴ Хадгаламжийн байгууллагад банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.

сарынхаас 1.3 хувь буюу 40.0 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 51.9 хувь буюу 1097.4 тэрбум төгрөгөөр өсч 3211.4 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сарынхаас 1.4 хувь буюу 35.9 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 59.9 хувь буюу 956.5 тэрбум төгрөгөөр өсч 2552.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хувийн хэвшил болон иргэдэд олгосон зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд буурч эхэллээ.



Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 55.5 хувь нь хувийн хэвшил, 44.2 хувь нь иргэд, 0.2 хувь нь улсын байгууллага, 0.1 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 93.4 хувийг хэвийн зээл, 1.1 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 5.5 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4.4 нэгж хувиар буурчээ.



Банк бус санхүүгийн байгууллагуудын⁵ нийт зээлийн өрийн үлдэгдэл нь 2011 оны 4 дүгээр улирлын байдлаар 119.0 тэрбум төгрөг байв. Нийт санхүүгийн байгууллагуудаас эдийн засагт оруулсан санхүүжилт нь 5900.5 тэрбум төгрөг байна.

Хүү


Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2012 оны 3 дугаар сард өнгөрсөн оны мөн үеэс 3.6 нэгж хувиар өсч жилийн 14.42 хувь болов. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү⁶ өмнөх сарынхаас 0.5 нэгж хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 2.1 нэгж хувиар өсч жилийн 17.9 хувь болсон бол гадаад валютынх өмнөх сараас 1.6 нэгж хувь, өнгөрсөн оны мөн үеэс 0.7 нэгж хувиар буурч жилийн 12.4 хувь болжээ. Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү сүүлийн саруудад тогтвортой, өөрчлөлт багатай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү жилийн 10.8, валютын хадгаламжийнх 4.9 хувь байв. Төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж жилийн хүү 2.8 хувь, валютынх 1.4 хувь байлаа.

Мөнгөний зах

2012 оны 3 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 418.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 12.17 хувь байна.

⁵ Санхүүгийн байгууллагад банк болон бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллагаас гадна банк бус санхүүгийн байгууллага орно.

⁶ Зарласан хүү.



2012 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөд 520.3 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 227.9 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 545.5 тэрбум төгрөг, валютын нөөцөд 364.0 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2012 оны 3 дугаар сарын эцэст 1318.80 төгрөг болж, өмнөх сараас 21 төгрөгөөр чангарч, өмнөх оны мөн үеэс 124 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1333.28 төгрөг байв.